

Цуврал хичээл-6

БОНД

Хөрөнгийн зах зээл дээр хувьцаанаас гадна өрийн бичгийн арилжаа явагддаг. Зээл олгосон болохыг гэрчилж буй үнэт цаасыг бонд гэнэ. Бонд ихэнх тохиолдолд урт хугацааны хөрөнгийг олж авах санхүүгийн хэрэгсэл болдог. Бонд нь банкны зээлтэй төстэйгээр тодорхой хугацаатай, тодорхой хэмжээний хүүтэйгээр, тодорхой хэмжээний мөнгөний өр тавьж байгааг гэрчилсэн бичиг юм.

- Бондод бичигдэх зүйлс:
- Гаргасан огноо
- Төлөгдөх хугацаа
- Нэрлэсэн үнэ
- Гаргасан этгээдийн нэр
- Дугаар
- Хүүгийн хувь
- Танилцуулга, анхааруулга
- Гарын үсэг

Бондын төрлүүд:

- Санхүүгийн агуулгаар нь
- Зах зээлээр нь

Санхүүгийн агуулгаар нь бондыг шулуун, хөрвөдөг, хүүгүй бонд гэхээс гадна үүрд мөнхийн бонд, индекстэй уясан ба орлогын бонд гэж ангилна.

Шулуун бонд – энэ бонд бусад үнэт цаасанд хөрвөдөггүй, хүүг нь шулуун аргаар тооцдог буюу хүү нь тогтмол байдаг.

Хөрвөдөг бонд – бусад үнэт цаас руу хөрвөнө. Энэ бонд дараах бичиглэлтэй байна.

Жишээлбэл:

. ангиллын бондыг 1 бүрийг нь. төгрөгөөр бодож 2015 оны 1—р сарын 31-ний дотор хувьцаа руу хөрвүүлж болно. гэх мэтээр.

Хүүгүй бонд – бондыг олгохдоо дискаунт хийдэг.

Жишээлбэл:

10% хүүтэй 1000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 3 жилийн хугацаатай бондын хагас жил тутмын хүүгийн төлбөр 50 төгрөг бол 3 жилийн хүүгийн төлбөр 300 төгрөг болно. Бонд гаргаж байгаа газар 1000 төгрөгний нэрлэсэн үнэтэй хүүгүй бондыг зарахдаа энэхүү нэрлэсэн үнээс хүүгийн хувь хэмжээг хасаж тооцно. Бондын хугацаа дуусахад бонд эзэмшигч 1000 төгрөгөө авна гэсэн үг.

Үүрд мөнхийн үнэт цаас – энэхүү үнэт цаасыг дайны дараах сэргээн босголтын үед гаргаж байсан. Төлөгдөх хугацаа нь тодорхой биш байдаг бөгөөд харин хүүгийн төлбөрийг жил болгон хийнэ.


Индекстэй уясан бонд – жижиглэн худалдах үнийн индексээс хамаарч хүү нь өөрчлөгдөж байдаг бонд.

Орлогын бонд – санхүүгийн хүндрэлд орсон буюу өөрчлөгдөх гэж байгаа

компани тодорхой хугацаанд хүү төлдөггүй бөгөөд хүү төлөх хугацаагаа зааж өгсөн байна.

ТОГТМОЛ ОРЛОГОТОЙ ЭРСДЭЛ БАГАТАЙ ҮНЭТ ЦААС БОЛ БОНД ЮМ.

Бонд буюу өрийн бичиг нь тодорхой хугацааны дараа үндсэн төлбөр болон хүү мөнгөн, эсхүл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн үнэт цаас юм. Өөрөөр хэлбэл та компанийн бонд худалдан авна гэдэг нь тухайн компанид тодорхой хугацаатай, тогтсон хүүтэйгээр мөнгө зээлж байна гэсэн үг. Бондын өгөөж нь түүний хүү байдаг ба бондын хугацаа дуусмагц Та үндсэн мөнгөө хүүгийн хамт эргүүлж авах болно. Бонд нь урт хугацаат (ихэвчлэн 3-аас дээш жил) үнэт цаас бөгөөд хэрэв мөнгө хэрэгтэй болбол хувьцаатай адил дуртай үедээ хоёрдогч зах зээл дээр борлуулж болдог. Бондыг хэн гаргаж байна гэдгээс хамааран дараах байдлаар 2 ангилж болно.



Засгийн газраас, мөн орон нутгийн засаг захиргаанаас тодорхой төсөл хөтөлбөр болон төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор бонд гаргадаг. Харин компаниудын хувьд хөрөнгө босгож, бизнесээ өргөжүүлэх, шинэ төсөл хэрэгжүүлэх зорилгоор бонд гаргадаг.

ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД СУУРЬ ХҮҮГ ТОГТООДОГ

Аливаа Улсын **Засгийн газрын** бондыг найдвартай эргэн төлөгдөнө гэж үздэг учир хамгийн эрсдэл багатай үнэт цаасанд тооцдог. Тийм ч учраас засгийн газрын бондын хүү хамгийн бага байдаг бөгөөд бондын зах зээл дээр төдийгүй үнэт цаасны зах зээл дээрх суурь хүүг тогтоодог юм. Өөрөөр хэлбэл засгийн газрын бондын хүүг эрсдэлгүй хүү гэж үздэг. Бондын хүү нь хугацаанаасаа хамааран янз бүр байдаг бөгөөд эргэн төлөгдөх хугацаа нь урт болох тусам хүү нь нэмэгддэг.

Харин **Компанийн** бонд нь хувьцааг бодвол өгөөж багатай мөн эрсдэл багатай байдаг бол банкны хадгаламжтай харьцуулахад өгөөж, эрсдлийн хувьд арай илүү байдаг. Мөн ЗГ-ын бондноос илүү хүүтэй, түүнийгээ дагаад эрсдэл ихтэй байдаг. Компанийн бондын хүү нь бонд гаргагчийн санхүүгийн байдал, санхүүжилтын хэрэгцээ шаардлага буюу эрсдлийн хэмжээнээс шууд хамаардаг. Ж нь: бонд гаргагч нь нэр хүндтэй, санхүүгийн чадвар сайтай том компани буюу эрсдэл харьцангуй багатай гэж үзвэл бондынх нь хүү харьцангуй бага байна. Харин жижиг, олонд төдийлөн танигдаагүй бөгөөд богино хугацаанд санхүүжилт олох шаардлагатай компанийн бондын хүү эрсдлээ дагаад өндөр байдаг. Хөрөнгө оруулагчид хэр их эрсдэл хүлээх чадвартайгаасаа хамааран хувьцаа эсвэл бонд сонгох шийдвэрээ гаргадаг.

БОНД БОЛОН ХУВЬЦААНЫ ЯЛГАА

ХУВЬЦАА	БОНД
Эргэн төлөгдөх нөхцөлгүй хөрөнгө оруулалт.	Тодорхой хугацааны дараа эргэн төлөгдөнө.
Өмчлөгчийн хувьд өөрт ноогдох ноогдол ашиг авна.	Зээлийн эзний хувьд зээлийн хүүг авна.
Хувьцааны ноогдол ашиг компанийн ашигт ажиллагаанаас хамаарах тул тогтмол биш байж болно.	Компанийн ашиг алдагдлаас үл хамааран анх тогтсон хүүг тогтмол авна.
Хөрвөх чадвар сайтай. Хоёрдогч зах зээл дээр арилжаалагддаг, өөрөөр хэлбэл хувьцаа эзэшигчид хоорондоо арилжиж болдог.	Хөрвөх чадвар хувьцаанаас сул. Гэхдээ хүссэн үедээ хоёрдогч зах зээл дээр арилжиж болно.
Компани оршин тогтнох бүх л хугацаанд хүчин төгөлдөр.	Зээлийн хугацаанд хүчин төгөлдөр.
Компани дампуурвал хувьцаа эзэмшигчид өөрт ноогдох хөрөнгийг компанийн бүх өр төлбөр, зээлийг барагдуулж дууссаны дараа авдаг.	Компани дампуурвал зээл олгогчид өөрийн зээлдүүлсэн хөрөнгийг хүүгийн хамт хамгийн түрүүнд авдаг.
Ашиг өндөр -> Эрсдэл өндөр	Ашиг бага -> Эрсдэл бага

БОНДЫН АРИЛЖАА

Бондын арилжаа 1996 оны 10-р сарын 25-нд Засгийн газрын бондын арилжаагаар эхэлсэн түүхтэй. Манай Засгийн газар 1996 онд төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор анх бонд гаргаж байсан бол 2011 онд Засгийн газрын бондын арилжаа 14 удаа явагдаж, “4000 төрийн албан хаагчдыг

орон сууцны урт хугацаат зээлд хамруулах” хөтөлбөрийн санхүүжилтэд 65.0 тэрбум төгрөгийн бонд, ноос ноолуурын болон жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүжилтэд 171.7 тэрбум төгрөгийн бонд арилжиж, нийт 236.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 2.4 сая ширхэг бондыг арилжаалжээ.

Харин Хөрөнгийн биржийн анхны бондын арилжаа 2001 оны 6-р сарын 8-нд явагдаж байсан. Өнгөрсөн хугацаанд нийт 9 компани 15 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий бонд гаргаж анхдагч зах зээлд арилжаалсан байна. Анх 2001 онд Барилга корпорациас “Шинэ зуун” бондыг гарган арилжаалсан. Түүнээс хойш нийт 10 компани бонд гарган амжилттай арилжаалсан бөгөөд эдгээр бондыг гол төлөв барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниуд гаргасан байдаг. Бонд гаргасан нийт 9 компанийн 4 нь ХХК байгаа нь хаалттай компани ч бонд гаргах замаар хөрөнгийн зах зээлээс хямд эх үүсвэр татах боломжтойг нотолж байна.

ЗГ-ын бондын хугацаа нь 3 сараас 5 жилийн хооронд байгаа бол өгөөж нь 5.4-14.5 хувийн хооронд байжээ. 2011 оноос эхлэн ЗГ-аас гаргадаг бондын хугацаа 1 жилээс дээш болсон байна. Харин компанийн бондын хугацаа нь 8 сараас 2 жилийн хооронд байсан бөгөөд өгөөж нь 16.2-21.6 /сарын 1.35-1.8 хувь/ хувийн хооронд байсан байна.

2014 оны 10 сарын 21-ний Санхүүгийн зохицуулах хорооны 389 тоот тогтоол болон Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 10-р сарын 23-ны өдрийн 169 дугаар тушаалаар 100.0 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй Монгол Улсын Засгийн газрын үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгийн зах зээлд арилжаалах шийдвэр гарсан.

Сангийн яамнаас ирүүлсэн нөхцөлийн дагуу олон нийтэд санал болгох жижиглэнгийн нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй ЗГҮЦ-ыг долоо хоног бүр МХБ-ээр арилжаалах бөгөөд тус үнэт цаасны хүүгийн хэмжээ нь тухайн долоо хоногт Монголбанкнд арилжигдсан ижил хугацаатай ЗГҮЦ-ны жигнэсэн дундаж хүүгийн хэмжээгээр тогтоогдоно.

Засгийн газрын зүгээс ийнхүү хөрөнгийн зах зээл, түүнд оролцогчдыг дэмжих зорилгоор эрсдэлгүй, татвараас чөлөөлөгдөх, богино хугацаат ЗГҮЦ-ыг хөрөнгийн биржийн арилжаагаар олон нийтэд чөлөөтэй анхдагч болон хоёрдогч зах зээлд арилжихаар болсон. Хугацааны хувьд 3 сар, 6 сар, 1 жилийн хугацаатай байх юм.

Монголын хөрөнгийн биржээр арилжигдах 3 сарын хугацаатай Засгийн газрын үнэт цаасны захиалгыг 2014 оны 10-р сарын 29-ний өдрөөс эхэлж эрх бүхий үнэт цаасны компаниудаар авах бөгөөд 2014 оны 11-р сарын 04-ний өдөр эхний арилжаа хийгдсэн.